

**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2020 оны 05 сарын 12 өдөр

Дугаар 4/16

Арвайхээр сум

「 Анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын
улирлын үр дүнгийн урамшууллыг ажлын үр дүнтэй
уялдуулан олгох тухай

Эрүүл мэндийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.4, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.4, Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал журам батлах тухай” 05 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 1.2.1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилгоор байгууллагын үйл ажиллагааны үр дүнгийн үзүүлэлтийг тухайн улирлын урамшуулалтай уялдуулан олгох шалгуур үзүүлэлт, аргачлалыг нэгдүгээр, албан хаагчдын үр дүнгийн урамшуулал олгоход үнэлэх шалгуур, аргачлалын жишгийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Тушаалыг хэрэгжүүлж, урамшуулалд зарцуулаагүй санхүүжилтийг албан хаагчдын сурч хөгжих арга хэмжээнд зарцуулахыг сум, өрхийн Эрүүл мэндийн төвийн дарга нарт үүрэг болгосугай.

3. Улирал бүрийн үнэлгээг шалгуурын дагуу нэгтгэж, дараа улирлын эхний ажлын 10 хоногт багтаан дүгнэхийг Хэлтсийн дарга нарт, Байгууллагуудад хүргэж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ мэдээллийн хэлтэс (Я.Жаргал), Санхүүжилтийн зарцуулалтад хяналт тавьж, зохицуулалт хийж ажиллахыг Ерөнхий санхүүч (Б.Валя) нарт үүрэг болгосугай

ДАРГА  Н. ОЮУНТУЯА

622001063

Эрүүл мэндийн газрын даргын
2026 оны 05 дугаар сарын 12-ны
өдрийн 4 тушаалын нэгдүгээр
хавсралт



БАЙГУУЛЛАГЫН УЛИРЛЫН ҮР ДҮНГИЙН УРАМШУУЛАЛ
ОЛГОХ ХЭМЖЭЭГ ТООЦОХ АРГАЧЛАЛ

№	Үр дүнг үнэлэх үзүүлэлтүүд	Байгууллагын үр дүнгийн урамшуулалын хасагдах хэмжээ хувиар	Үнэлгээг тооцон гаргаж хамтран нэгтгэх албан хаагч
НЭГ. ҮР ДҮНГИЙН ШАЛГУУР			
1.1	0-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	Тухайн улиралд гарсан тохиолдол бүрийн тоогоор 10 хувь /анхан шатны байгууллагын үйл ажиллагаанаас шалтгаалсан эсэхийг харгалзан/	ЭМГ-ын Хүүхдийн мэргэжилтэн
1.2	Эхийн эндэгдэл	Тухайн улиралд гарсан тохиолдол бүрийн тоогоор 20 хувь /анхан шатны байгууллагын үйл ажиллагаанаас шалтгаалсан эсэхийг харгалзан/	ЭМГ-ын Эх барихуйн асуудал хариуцсан мэргэжилтэн
1.3	Нийт нас баралт	Аймгийн дундажаас өндөр бол 5 хувь	ЭМГ-ын Статистикч их эмч, Халдварт ба халдварт бус өвчлөл хариуцсан мэргэжилтэн
1.4	Өвчний шалтгаант эмнэлгийн бус нас баралт	Нийт нас баралтад эзлэх хувь аймгийн дундажаас өндөр бол 5 хувь	
1.5	Харьяалалын хүн амын сэргийлж болох осол гэмтлийн нас баралт	Тухайн улиралд гарсан тохиолдол бүрийн тоогоор 5 хувь	
1.6	Харьяалалын хүн амын ЗСС-ны шалтгаант нас баралт	74 хүртэлх насанд /10000 хүн амд/ аймгийн түвшнээс өндөр бол 5 хувь	
1.7	Харьяалалын хүн амын Хорт хавдрын шалтгаант нас баралт	74 хүртэлх насанд /10000 хүн амд/ аймгийн түвшнээс өндөр бол 5 хувь	
ХОЁР.ҮЙЛ ЯВЦЫН ШАЛГУУР			

2.1	Жирэмсний хяналт	Хяналтгүй болон хожуу хяналтын тоогоор 5 хувь	ЭМГ-ын Статистикч эмч, барихуйн асуудал хариуцсан мэргэжилтэн	их Эх
2.2	Артерийн даралт ихсэх өвчний эрт илрүүлэг	Тухайн жилд хамрагдвал зохих хүнээс тухайн улиралд хамрагдах хүний тоогоор хувийг тооцож хангалтгүй бол 5 хувь /Хэрэгжилт 70 хүртэл хувь бол "хангалтгүй" гэж үнэлнэ	ЭМГ-ын Статистикч эмч, Халдварт ба халдварт бус өвчлөл хариуцсан мэргэжилтэн	их
2.3	Чихрийн шижин өвчний эрт илрүүлэг	Тухайн жилд хамрагдвал зохих хүнээс тухайн улиралд хамрагдах хүний тоогоор хувийг тооцож хангалтгүй бол 5 хувь /Хэрэгжилт 70 хүртэл хувь бол "хангалтгүй" гэж үнэлнэ		
2.4	Хөхний хорт хавдрын эрт илрүүлэг	Тухайн жилд хамрагдвал зохих хүнээс тухайн улиралд хамрагдах хүний тоогоор хувийг тооцож хангалтгүй бол 5 хувь /Хэрэгжилт 70 хүртэл хувь бол "хангалтгүй" гэж үнэлнэ		
2.5	Умайн хүзүүний хавдрын эрт илрүүлэг	Тухайн жилд хамрагдвал зохих хүнээс тухайн улиралд хамрагдах хүний тоогоор хувийг тооцож хангалтгүй бол 5 хувь /Хэрэгжилт 70 хүртэл хувь бол "хангалтгүй" гэж үнэлнэ		
2.6	Зөрчлийн гомдол мэдээллийн тоо	Тухайн улиралд гарсан тохиолдол бүрийн тоогоор 10 хувь		
2.7	Салбарын ёс зүйн хорооны үнэлгээ	Тухайн улиралд гарсан тохиолдол бүрийн тоогоор 10 хувь		



Эрүүл мэндийн газрын даргын
2026 оны 05 дугаар сарын 18-ны
өдрийн 4/16 тушаалын хоёрдугаар
хавсралт

АЛБАН ХААГЧИЙН АЖЛЫН ҮР ДҮНД ҮНЭЛГЭЭ
ХИЙХ ЖИШИГ ШАЛГУУР

..... албан тушаалтай овогтой
2026 оны улирлын үр дүнгийн үнэлгээ оны сарын өдөр

Албан тушаал	Үр дүнгийн үндсэн шалгуур	Үндсэн шалгуурыг тодорхойлох тусгай үзүүлэлт	Авбал зохих оноо	Өөрийн үнэлгээ	Үнэлгээний багийн үнэлгээ	Мэдээллийн эх сурвалж
А. Эрүүл мэндийн ажилтанд тавигдах нийтлэг шалгуур үзүүлэлт						
Эрүүл мэндийн ажилтан	Үйлчилгээний чанар	1. Хүлээгдэл чирэгдэлгүйгээр үйлчилгээ үзүүлсэн байдал;	5			- Байгууллагын дотоод хяналтын багийн үнэлгээ, иргэдийн сэтгэл ханамжийн үнэлгээний судалгааны дүн - Хугацаатай бичиг шийдвэрлэлт / ирсэн явсан бичгийн бүртгэл/ - Өгсөн үүрэг даалгаварын биелэлт
		2. Ёс зүй, харьцааны байдал; Үйлчлүүлэгч, хамт олны сэтгэл ханамжийн байдал.	5			- Байгууллагын ёс зүйн багийн үнэлгээ - Үйлчлүүлэгч, болон хамт олноос google form ашиглаж судалгаа авах ажлыг жилд 2 удаа авч болно
	Ажлын ачаалал, хариуцлага	1. Ажлын цаг ашиглалт; 2. Хариуцсан өмч хөрөнгийн ашиглалт;	5			Ажлын цагийн бүртгэл, хамт олны үнэлгээ Хөрөнгө эзэмшигчийн картанд байгаа эд хогшлын ашиглалт хамгаалалтыг үзнэ

	Эмнэлгийн тусламж, үйлчилгээнд оруулсан хувь нэмэр	1. Эмчилгээ үйлчилгээнд шинэ бүтээл, оновчтой санааг нэвтрүүлэн, эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлсэн байдал; 2. Ажлын идэвх, олон нийтийн арга хэмжээнд оролцсон байдал, Ажлын ачаалал;	4			-Судалгаа, дүгнэлт хийж илтгэл хэлэлцүүлсэн үр дүн - Шинэлэг ажил санаачлан үр дүнд хүрсэн байдал Хамт олны үнэлгээнд нэмэлт асуулт оруулан үнэлж болно
Б. Тусгай шалгуур үзүүлэлт						
Эмнэлгийн мэргэжилтэн	Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар	1. Эмчилгээ, үйлчилгээний стандартыг мөрдөж байгаа байдал;	6			-Байгууллагын чанарын багийн үнэлгээ -Ижил мэргэжилтний үзлэг -ЭМС-ын тушаал шийдвэрээр сургалт, мэдээлэл хийсэн байдал -Түгээмэл үйлдлийн стандартын гардан үйлдлийн үнэлгээ -Мөн удирдамж, эрхзүйн мэдлэгийн үнэлгээ / асуулт, тестээр /
		2. Халдвар хамгааллын дэглэмийг мөрдөж байгаа байдал;	6			Байгууллагын халдвар хамгааллын багийн үнэлгээ
		3. Эмчилгээ, үйлчилгээний талаар гаргасан гомдол;	5			Тухай ажилтантай холбоотой гомдол тухай улиралд гарсан эсэх
		4. Үйлчлүүлэгчид зөвлөгөө, сургалт, мэдээлэл өгсөн байдал;	4			-Иргэдэд хандсан сургалт мэдээллийн үйл ажиллагааны чанар, үр дүн -Зөвлөгөө өгөх үр чадвар,хүртээмж -Бэлтгэсэн гарын авлага, цахим контент
		5.Төрийн албан хаагчийн төлөвлөгөө, ажлын байрны тодорхойлолтод заасан ажлын гүйцэтгэл, чанар;	5			-Тухайн улирлын үйл ажиллагааны төлөвлөлт, тайлагналт - Байгууллагын багуудын үйл ажиллагаанд түүний оролцоо - Удирдлагын зүгээс өгсөн үүрэг даалгаварын биелэлт - Хариуцсан арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт - Ажлын чиг үүрэгтэй холбоотой статистик үзүүлэлтүүд

						- Анхан шатны бичиг баримт хөтлөлт, үнэн зөв байдал
						-Сургалтад оролцсон байдал - Зэрэг хамгаалалт - Шинэ ажилтныг дагалдуулан сургасан, дагалдан суралцсан байдал
			4			
			59 оноо			

Тайлбар: 0-6 онооны системээр үнэлнэ. Нийт 59 оноо авахаас хэдэн оноо авснаар урамшуулалын хувийг тооцон олгоно.

- Тухайн ажилтны ажлын чиг үүрэг, онцлогтой холбоотой шалгуурт нэмэлт өөрчлөлт оруулна.
 - Ажил дүгнэх баг тухайн ажилтны ажлын үр дүнг илтгэх шалгуур үзүүлэлтийг тухайн улирлын статистик үзүүлэлтийг харгалзан үнэлнэ.
 - Үнэлгээний баг ажилтны өөрийн үнэлгээг харгалзан харилцан ярилцаж үнэлнэ.
 - Хүн тус бүрийн үнэлгээг нэгтгэн санхүүгийн баримтад хавсаргана. Ажилтан бүрийн үнэлгээний хуудсыг үнэн зөв хөтлөж баталгаажуулсан байна.
- Үнэлгээг хийсэн ажлын хэсгийн ахлагч: / /

Гишүүд : / /

Үнэлгээг хүлээн зөвшөөрсөн / /